



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18 -ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн 12 ширхэг, нийт 581,406,474.00 (таван зуун наян нэгэн сая дөрвөн зуун зургаан мянга дөрвөн зуун далан дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашинуудыг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Тогтоолд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004801  
9-1 huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 2-дугаар сарын 28-ны өдрийн  
 3-дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСЧ, ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД БҮРТГЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгө эзэмшигч төрийн өмчит байгууллага	Шилжүүлэх Автомашинны нэр, марк	Улсын		Үйлдвэр- лэсэн он /Ашиглалтад орсон он	Хөрөнгийн балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага
			Сери	Дугаар				
1	"Засгийн газрын автобааз" ТӨААТҮГ	Тоёото Ландкрузер 105	УБЗ	0134	2005/2005	40,719,683.00	40,719,683.00	Төв аймаг Баянчандмань сумын ЗДТГ
2	"Засгийн газрын автобааз" ТӨААТҮГ	Тоёото Ландкрузер 200	УБЗ	0084	2005/2005	258,000,000.00	258,000,000.00	Хэнтий аймгийн Баянхутаг сумын ЗДТГ
3	"Засгийн газрын автобааз" ТӨААТҮГ	Тоёото Ландкрузер 200	УБЗ	0067	2013/2013	125,000,000.00	125,000,000.00	Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
4	Говь-Алтай аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ланд круйзер 105	ГАУ	6354	2002/2007	65,000,000.00	65,000,000.00	Говь-Алтай Орон нутгийн Өмчийн газар
5	Говьсүмбэр аймгийн мэргэжлийн хяналтын газар	УАЗ 469	ГСА	3764	2010/2010	20,000,000.00	20,000,000.00	Говьсүмбэр Орон нутгийн Өмчийн газар
6	Дундговь аймгийн мэргэжлийн хяналтын газар	Suzuki Swift	ДУА	7272	2003/2012	9,050,000.00	9,050,000.00	Дундговь Орон нутгийн Өмчийн газар
7	Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын газар	Фургон	ДОР	7514	2008/2008	10,220,000.00	10,220,000.00	Дорнод Орон нутгийн Өмчийн газар

8	Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын газар	Мотоцикл	ДО	3419		1,680,000.00	1,680,000.00	Дорнод Орон нутгийн Өмчийн газар	
9	Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ниссан экстрейл	УНС	1293	2001/2008	15,620,000.00	15,620,000.00	Өмнөговь Орон нутгийн Өмчийн газар	
10	Увс аймгийн мэргэжлийн хяналтын газар	Фургон	УНЗ	1156	2009/2010	15,000,000.00	15,000,000.00	Увс Орон нутгийн Өмчийн газар	
11	Ховд аймгийн мэргэжлийн хяналтын газар	УАЗ Пургон	ХОА	5740	2010/2010	20,000,000.00	20,000,000.00	Ховд Орон нутгийн Өмчийн газар	
12	Орхон аймгийн мэргэжлийн хяналтын газар	Мотоцикль				1,116,791.00	1,116,791.00	Орхон Орон нутгийн Өмчийн газар	
							<b>581,406,474.00</b>	<b>581,406,474.00</b>	
<b>Нийт дүн</b>							(таван зуун наян нэгэн сая дөрвөн зуун зургаан мянга дөрвөн зуун далан дөрвөн)		